

## **ТАНИЛЦУУЛГА**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт нь татвар төлөгчийг ялгавартай байдалд оруулах, үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн этгээдэд татварын ачаалал үүсгэх, өмчийн үр өгөөжийг ашиглах боломжийг хугацаагаар хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тус заалтаар барилга, байгууламжийн НӨАТ-ыг 10 жил, тоног төхөөрөмжийн НӨАТ-ыг 5 жил, бусад үндсэн хөрөнгийг шууд хасахаар зохицуулсан байна. Энэхүү зохицуулалт нь дараах хүндрэлүүдийг үүсгэж байна:

- Татварын ачаалал бодитоор нэмэгдэж байна. НӨАТ нь хэрэглээний татвар байх ёстой боловч уг зохицуулалтын улмаас бизнесийн зардал болж хувирч, татварын үйл ажиллагаанд баримтлах зарчмууд алдагдаж байна.
- Аж ахуйн нэгжийн санхүүгийн дарамт нэмэгдэж байна. Их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүд НӨАТ-аа шууд хасаж чадахгүйгээс татварын өр үүсэх, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орох нөхцөл бий болж байна.
- Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байна. Үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн бизнесүүд импорт, худалдаанд суурилсан үйл ажиллагаатай харьцуулахад татварын дарамтад ихээр орж, өрсөлдөх чадвар нь буурч байна.

Мөн Монгол Улсын одоогийн энэхүү зохицуулалт нь олон улсын нийтлэг жишгээс зөрүүтэй байна.

Хуулийн төслийн зорилго нь үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотойгоор төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасах хугацааг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, татварын ачааллыг бууруулах, хөрөнгө оруулалтыг дэмжихэд оршино.

Хуулийн төсөл гурван зүйлтэй. Нэгдүгээр зүйлд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг хүчингүй болгох зохицуулалтыг, хоёрдугаар зүйлд шилжилтийн зохицуулалтыг, гуравдугаар зүйлд хуулийн дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан.

Хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавх сайжирч, хөрөнгө оруулалтын идэвх, аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэл, нэмүү өртөг бий болгох үйл ажиллагаа идэвхжиж, татварын тогтолцооны үр ашиг, ил тод байдал сайжирч, аж ахуйн нэгжийн санхүүжилтийн зардал буурч, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой байна.

## **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**